

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLI (483)

Улаанбаатар

2017

“БИ, ЧИ, ТА”-ЫН ХЭЛ, СОЁЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД

Д.Баасанбат

Үндэстний хэл бол харилцааны чухал хэрэглүүр төдийгүй тухайн ард түмний оюуны соёлын тусгал болдог. Хүн өөрийгөө, бас соёлыг бүтээдэг. Үүнийхээ ачаар хүн өөрийнхөө дутмаг шинжийг тодорхойлох боломжтой. Гэвч хүн гэдэг бусдыг мэдэхдээ мэргэн хэрнээ өөрийгөө мэдэхдээ харалган ажээ. Бүр “бусдын гэмийг хараадаа уулын бүргэд, өөрийн гэмийг хараадаа өндгөө дарсан шувуу” ажгуу.

Хүн өөрийгөө танин мэдэж, өөрийнхөө уг чанарыг олохын тулд юу ч хийдэггүй. Тиймээс хойч үеийнхнийг өөрийг нь олуулах, нээх, өөрийгөө танин мэдэхэд нь эцэг эх, багш нар, ахмадууд ер нь хэн бүхэн туслах ёстой. Хүн буюу би гэгч нь бие, хэл, сэтгэлийн бүрдэл бодгал юм. “Бие” нь биет бодот зүйл бөгөөд шороо, ус, хий, гал, огторгуй хэмээх 5 махбодоос бүтнэ хэмээдэг. Харин “Би” бол хоосон чанар бүхий үл баригдах хийсвэр ухагдахуун, бодгүй зүйл. Тийм учраас биеэс “би”-г хайвал олохгүй. Таны уушги, зүрх, элэг, бөөр юм уу, нүд, чих, ам, хамар, арьс таны бодож байгаа “би” мөн үү гэвэл биш, гар хөл, нуруу тургуу гээд тулж байгаа бүхэн нь “би” юм уу бас л биш. Эсвэл таны сайн сайхан, муу муухайг төлөөлж чадах зан чанарууд хайр энэрэл, уур уцаар, гомдол цөхрөл, баяр хөөрийг “би” гэдэг юм уу гэтэл үгүй. Ингэхээр миний бие, хэл, сэтгэлийн аль нь ч миний “би”-г төлөөлж чадахгүй юм байна. Тэгэхээр барих биегүй, хайх мөргүй, бодоход бодгүй, “би” гэж чухам юу юм бэ?. Тэнгэрт шувуу нисэх нь бодтой ч мөр нь үлдэггүй нь бодгүй шиг “Би” гэж биеэ хэлдэг боловч бид “би”-гээ мэддэггүй нь хачирхалтай. Тэгвэл “би” гэдэг чинь хаана ч байхгүй хоосон юм биш үү?

Эрдэмт лам Галшиев “Билгүүн толь” судартаа “Цуг юм уу ангид болохыг шинжилсэн ахул “би ба минийх” гэж байхгүй, бясалга зүүдэнд орсон амьтны бүжиг мэт нэр төдийгөөс өөр юу байх билээ” гэжээ.

Хүн бүр “би”-гээ ямагт урьдал болгож “би” гэх аминч үзэл, биеэ өмөөрөх, хамгаалах санаа агуулж байдаг. Өдөр бүр буруу хазгайл хийж, буцаж, няцаж, булздаг хэрнээ өөрийгөө өмөөрөх, өмчлөх, “би би” гэх төвчлөх үзлээс ангижирдагтүй. Жишээ нь гэр бүлд нөхөр нь “би” л олдог, эхнэр нь “би” л хийдэг, хүүхэд нь “намайг л” загнадаг, албан байгууллага дээр “би л” дарга, “би л” захирал, “би л” эмч, “би” бол жижүүр, “би” худалдагч гээд л... надаас өөр хэн ч байхгүй гэсэн шиг авирлана. Бидний төсөөлснөөр “би” гэж угаас байхгүй, хоосон атал өөрийн “би”-г атаяа хорсол, шунал хүсэл, эрх мэдлийн хүчээр бий болгож буруу үзлийн намагт унан “би би би” хэмээн чанга чангаар хашхирч, туйлширч, бусдын дээгүүр харж, зөвхөн “би”, “минийх” гэсэн харамлах, өмчлөхийг сэтгэлээр үйлдэн зовлонгийн намагт живнэ. Энэ “би”-ийн бий болгодог атаяа, шунал, мунхаг, хорт сэтгэлийн хор нь хүний алдаа буюу зовлонгийн өртөнцийг бүтээдэг ажээ. “Би”-ийн хоосныг мэдэхгүй хөтлөгдөн хөтлөгдсөөр, эрхийн инчдэхийн зуурхан

энэ яваа насаа зовлонгийн далай болгосоор яваад үхдэг ажээ. Би ба бусдын тухай үзэл ойлголт гэдэг бол хүн төрөлхтний танин мэдэхүйн хөгжлийн нэг гол гогцоо юм.

Хүн “би” гэх үзлээс салж “бид” болоод “та” гэж бодож, хэлж, хэрэгжүүлж чадвал зовлонгоос ангижирна. Үүний тулд өөрийгөө шоолж, шүүж, шүүмжилж, улайлгаж, илчилж, шийтгэж чадах агуу ухаан хэрэгтэй гэдгийг гүн ухаантан Д.Урианхай “Хүнд нэн тэргүүнээ байваас зохих хамгаас агуу чанар бол биеэ шоолох, хүн өөрийгөө шоолж, өөрийгөө ичээхэд дотроо бүрэн эзэн суусан цагт л хүн төрөлхтөн сая муугийнхаа гэмийг хална. Хүн төрөлхтөнийг хүний муу муухайгаас хойшлуулах ганц аврал нь хүн бүр дор дороо өөр өөрийн муу муухайг улайлгах, биеэ ичээн шоолох шийтгэл. Өөрийгөө шоолох гэгч юу вэ? Давын түрүүнд өөрийн гэмийг өөртөө улайлгаж биеэ зэмлэх, амьдралын “сүүдрийн” буруут өөрт үүрч, зөвийг өрөөлд өгөх, өрөөл бусдыг ямагт өөрөөсөө өмөөрч, биеэ гэмшлээр гэсгээх. Гэмшил л хүмүүн дотроосоо ариудаахын магад үүд, хүмүүний дотоод хороос гэтэлгэх хамгийн хоргүй ариун гэсгээл” гэжээ.

Монгол хэл, сэтгэлгээний үүднээс энд “би”, “чи”, “та”, “бусад” болгоныг ялгаварлалгүйгээр, ерөнхийлөн “хүн”-ийг үзэх үзэлтэй нь холбон үзэх нь зүйтэй.

“Хүн” гэдгийг “Би биш - Бусад” гэсэн утгаар хэрэглэсэн байхаас гадна үүний эсрэгээр “Би”, “Чи”, “Та”, “Бусад” болгоныг ялгаварлалгүйгээр ерөнхийлөн “Хүн” гэсэн ойлголтод багталцуулан зүйрлэсэн хэллэг ч бас цөөнгүй байна.

Хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зов

Хүн хүний хүчинд

Загас усны хүчинд

Хүн голбол нөхөргүй

Хүнс голбол хоолгүй

Хүн бүгд идтэй

Хүлэг бүгд хурдтай

Хүн удах тусам уйддаг

Мал удах тусам ижилсдэг

Хүний хэлээр хүн үхдэггүй

Нохойн хэлээр далай бузартдагтуй...

г.м. “Би”, “Бусад”-ыг өөртэйгөө адилсуулах ухамсар төлөвшиж бодитой болсныг гэрчлэх баримт гэлтэй. Хүн намайг яаж үзэж, үнэлж байна, би бусдыг тэгэж үзэх ёстой гэсэн сэтгээцийн чиглэл нэгэнт хэвшил зуршил болж ирсэнтэй холбоотой.

Монгол хэлэнд “би”-г өргөмжлөхгүйгээр молхи, мунхаг, өчүүхэн, доорд... гэх мэт үгийг хоршин хэрэглэсэн нь элбэг. “Би би би” хэмээн “үргэлж” хэлдэг хүний хувьд “бусад” бол хамгийн танигдашгүй зүйл байсаар иржээ. “Би” төвт үзлийн агуулга нь даруй биеэ үнэлэхийг хэлж байна. Ингэхлээр бусад хүнд бишрэл төрүүлнэ гэдэгтээ бат итгэх, ямар нэг үйл ажиллагаа хийх чадвартайдаа баттай итгэх, өөрийнхөө утга учрыг баттай мэдрэх гэсэн хүчин зүйлээр тодорхойлогдоно (Берис, 1986:61).

Өнөө үед монгол хүн мөнөөх хоосон “Би-биөз” хүн буюу бусдаас дээгүүрт тавих сэтгэлгээний хямралд орсон байна. “Би төвт үзэл”-д холбогдох монгол зүйрлэлийн нэг хэсэг нь “Өөрийн”, “Өөрөө” гэсэн үг хэллэгүүд бий.

Өөрийн толгой дээрх эврийг үзээгүй байж

Хүний толгой дээрх өвсийг үзэх

Өөрийн мууг үхтэл мэдэхгүй

Хүний мууг хүрсээр мэдэх

Өөрийн хүрзийг хайрлаад

Хүний шанагаар шавар хутгах

Өөрийн мууг хүн дээр
Өвлийн мууг хавар дээр

Өөрөө ойчсон хуухэд уйлдагтүй

Өөрийн хожгорыг мэдэхгүй байж

Хүний халзанг гайхаж элэглэх...

Г.М. хэллэг нь өөрийн юм өөртөө зөв, өөрийн юм өөртөө зохицой гэсэн шиг өрөнхий утгатай юм.

Өөрөө гэх ойлголт нь “Би”, “Чи / Та”-г ялган танъяж улмаар нэг тогтолцоот үзэл болгосны баримт, бас түүнийг хэлний өрөнхий нэг тэмдэглэгээ болгосны ч баримт болж байна..

“Би” гэх үзэл нь “өөрөө, биеэ” гэсэн үг хэллэгийн хүрээнд илэрдэг бол “бусад” хэмээх үзэл нь “чи”, “та”, “энэ”, “тэр” гэх төлөөний үгийн хүрээнд илэрнэ. Үүнийг лавшруулахын тулд би - бусад, би - хүн, би - чи, би - та, би - өөрөө гэсэн эсрэгцлийн агуулгыг авч үзвэл, би ба бусдын тухай ойлголт бол хүн төрөлхтний ухамсар сэтгэхүй хэлний харилцан хамаарлыг тайлбарлахтай салшгүй холбоотой юм. “Би”, “чи”, “та”-г багтаасан “хүн” хэмээх ойлголт өнөөгийн хүнд нэгэнт төлөвшөн байдгийг уг гарвал хувирлаар нь тайлбарлабал сонин биз.

“на” язгуур үг угтгаа “хүн” гэсэн утгатай учир “нар”, “нэр” дагавар нь тэр санааг хадгалснаас “мал нар”, “чулуу нар”, “дэвтэр нэр” гэж нэр бүхэнд дагадагтүй зөвхөн хүнтэй холбоотой нэрийг даган багш нар, эмч нэр, ах нар, эгч нэр гэж эгшиг зохицон ордгийг бага багаар эvdэж байгаа тохиолдол анзарагдах болов. Одоогийн Монгол хэлэнд хүн өөрийнхөө биеийг заан өгүүлэхдээ эртний “хүн” гэсэн утгатай “на-” язгуурт үгс *намайг, надаас надтай, над руу* гэхийн оронд шууд “би” биш “хүн” гэсэн утгаар хүнийг хэлсээр байхад (*намайг хэлсээр байхад*), хүнээс *асуулгүй* (*надаас асуулгүй*), *хүнтэй хамт* (*надтай хамт*) гэж хэлэлцдэг нь өгүүлэгч өөрийн биеийг “би” гэхээс илүү “хүн” гэж байгааг илэрхийлж байна (Ринчен, 1973:39) гэжээ.

Өвөр Монголын эрдэмтэн Цэцэнцогт “Монгол хэлэнд би, ми, ба, ман зэрэг б, м язгуурт үгс 1-р биеийн ганц болон олон тоог илтгэж, чи, та зэрэг “т, ч” язгуурт үгс 2-р биеийн ганц, олон тоог илтгэнэ” (Sečenčoγtu, 1988:1746) гээд “Та”-ийн ганц тоо, хүндэтгэх утгатай болсон нь хожмын хэрэг” гэж тэмдэглэжээ.

Тань - чинь-ийн хүндэтгэл.

Та - тэ (а ~ э) - тийн, тийм, тийш, төдий,

Та (э) ~ чи - тэнгэж, чингэж, (т-ч) цаана, цаанах, цааш,

Чи (т ~ ч, а ~ и) чинь, чинагш

Чинийх > чи+у+хи

Чингэх > тийн+хийх

Тийн - тэр мэт

Тийм - иймийн эсрэг

Тийм - мөн, зөв (Sečenčoγtu, 1988:2216).

Сонгодог бичгийн өмнөх үеийн бичгийн хэлэнд биеийн төлөөний нэрийн эртний үндсүүд бараг төлөв хадгалагдаж байсан бөгөөд харин өдгөө уламжлан үлдсэн бичгийн дурсгалуудын хэмжээнд авч үзвэл биеийн төлөөний нэлээд хэлбэр хадгалагдан үлдсэнгүй /5:41/.

Гэсэн харамлах, өмчэхийн сэтгээдээр үзүүлж бийгээд биеийн төлөөний нэрийн бий болноюу агаар, шумал, мунхад, жарт сэтгэлний хор нь хүний төлөөний нэрийн төлөөний буюудаг агаар. “Би”-ийн хоосныг Мэдүүгүй хөтөлбөрүүлж бийгээд хамин зуурхад хөтөлбөрүүлж бийгээд хамин зуурхад

Өвөг монгол хэлэнд

Бие	Ганц тоо	Олон тоо
I	min	man
II	tin	tan
III	*fin	*fan

Авианы харилцан нөлөөллийн дагуу гийгүүлэгч сурхах, тагнайших, солигдох зэрэг үзэгдлийн улмаас биеийн төлөөний нэрийн бүтцэд зохих өөрчлөлт гарчээ.

Бие	Ганц тоо	Олон тоо
I	bi < bin < min	ba < ban < man
II	či < čin < tin	ta < tan < tan
III	*xi < *xin < *fin	*xa < *xan < *fan

Анхдагч олон тоот төлөөний нэр

- I ba, man-u, man-dur, man-i, man-ača, man-iyar, man-luy-a
- II ta, tan-u, tan-dur, tan-i, tan-ača, tan-iyar, tan-luy-a
- III a, an-u, an-dur, an-i, an-ača, an-iyar, an-luy-a

Үүсмэл олон тоот төлөөний нэр

- I bida, bidan-u, bidan-dur, bidan-i, bidan-ača, bidan-iyar, bidan-luy-a
- II tede, eden-ü, eden-dür, eden-i, eden-eče, eden-iyer, eden-lüge

Ганц тоот биеийн төлөөний нэр

- I bi, min, nadur, nama-yi, nada-ača, nama-bar, nama-luy-a
- II či, čin-u, čim-a-dur, čima-ača, čima-bar, čima-yi, čima-luy-a
- III i, in-u, ima-dur, ima-yi, ima-ača, ama-bar, ama-luy-a

Дунд үеийн монгол хэлэнд

Авианы хөгжил, хувьслын улмаас эртний монгол хэлний үед байсан биеийн төлөөний нэрийн бүтцэд зарим нэгэн өөрчлөлт гарчээ.

Бие	Ганц тоо	Олон тоо
I	bi	ba
II	či	ta
III	*(h)i	*(h)a

Олон тоот биеийн төлөөний нэр нь бие ялган заах утгаа тогтвортой хадгалж байсан боловч тэр үеийн олонх аялгуунуудад олон тооны утгаа алдаж эхэлсэн тул түүний оронд үүсмэл болон төлөөлсөн нэр шинээр гарч ирсэн байна.

I	biden (=bi+den)
II	tadan (=ta+dan)
III	teden (=te+den)

Ганц тоот биеийн төлөөний нэрийн хэлбэр

Nom.	bi	či	*i
Gen.	min-u	čin-u	in-u
D-L.	nadur, nada	čima-dur, čima-da	ima
Acc.	nama-yi	cima-yi	ima-yi
Abl.	nama-ača, nada-ača	čima-ača	ima-ača, ima-dača
Ins.	nama-bar	čima-bar	ima-bar
Com.	nama-luya	čima-luya	ima-luya

Анхдагч олон тоот төлөөний нэрийн хэлбэр

Nom.	ba	ta	*a
Gen.	man-u	tan-u	an-u
D-L.	mandur, man-a	tan-dur, tan-a	an=dur, an-a
Acc.	man-i	tan-i	an-i
Abl.	man-ača	tan-ača	an-ača
Ins.	man-iyar	tan-iyar	an-iyar
Com.	man-luya	tan-luya	an-luya

Үүсмэл олон тоот төлөөний нэрийн хэлбэр

Nom.	bida	tede	
Gen.	bidan-u	teden-ü	
D-L.	bidan-dur	teden-dür	
Acc.	bidan-i	teden-i	
Abl.	bidan-ača	teden-eče	
Ins.	bidan-iyar	teden-iyer	
Com.	bidan-luya	teden-lüge... (Төмөртогоо, 1992:8).	

Одоо ч монголчуудын хэл ярианд “би - бид - бидэн - биднүүс, та - тад - тадан - тануус, энэ - эд - эдэн - эднүүс, тэр - тэд - тэдэн - тэднүүс” гэж хэлэлцсээр байна. Харин “би, чи, та” хэмэх биеийн төлөөний үгийг монгол хэлний тийн ялгалаар хувилгахад мөнөөх үг үгүй болж өөрчлөгднө.

“Би” - миний, надад, намайг, надаас, надаар, надтай, над руу

“Чи” - чиний, чамд, чамайг, чамаас, чамаар, чамтай, чам руу

“Та” - таны, танд, таныг, танаас, танаар, тантай, тан руу

гэх мэтээр хувилна.

“Би”-г төлөөлөн нэрлэхэд “өөрөө, өөрийнхөө, өөртөө” гээд өөр үг болно. Би-ийн утга нь *Би би гэх нь* (биээ өргөмжлөх, биээ тоох, биээ гайхуулах), *би явжс байна*, *Бээжин сууж байна* (аажуу уужуу ахиж дөхөх), *би чи-дээ хүрэх* (сайн муугаа дуудалцан хэрэлдэх), *би-ээс бие, бэлчихээс бөөс* (ядуу юу ч үгүй хоосон), *би гэж далай, чи гэж балай* (өөрийгөө өргөмжлөх, бусдыг доорд үзэх) гэх мэтээр өргөснө.

"Чи" нь хэл, утга, соёл, хэрэглээний хүрээнд *Чи би-дээ хүрэх* (хэрэлдэх), *Чи чи гэж чичлэх* (нүд үзүүрлэх), *Чи ч тархи, би ч тархи бие бие хардаггүй тархи* (эмээлийн бүүрэг оньсого)... гэх мэтээр өргөжин дэлгэрнэ.

"Та"-ын утгын өргөсөл нь *Ta энд суугтуун* (ахмад болон үл таних зочноо хүндэтгэн хэлэх үг), *Ta-аас өөр нэргүй, гуайгаас өөр алдаргүй* (эгэл жирийн хүн), *Баги та мөн үү?* Эрхэм *Ta, Таныг өргөмжилж байна...* гэх мэтээр өргөжин дэлгэрнэ. "Та" нь олон тооны дагавар болон тооны нэр авч олны утга илтгэнэ. *Ta бүхэн амгалан морилж явна уу?* *Ta нар минь сайн байцгаана уу?* Та бүхэн, та нар, та хоёр, тад, тадан... г.м. Та ~ Тан гэдгийн олон тоо нь *ta нар* буюу *тануус* юм.

"Та" нь хүний нэрийн дараа орвол хүндэтгэх утга илтгэнэ. Жишээ нь: ...Гомбожавтаны зохиол "Мэдэхгүйг хялбар болгосон хэмээх дохионы бичиг", Эрхэм хүндэт Ерөнхийлөгч Баттулга Та... гэх мэт. Үүнээс үзвэл, би, чи, та гэсэн биеийн төлөөний үгээс "Та" гэдэг нь илүү байр суурь орон зай эзэлж түүнийхээ хэрээр монгол хэлэнд "Ta" гэдэг үгийн утга өргөн, хэрэглээ их байсныг илтгэнэ. Жишээ нь: Гэр бүлд эхнэр нь нөхөртөө "Ta" гэж хандана, хүүхэд нь аав, ээж, ах эгч, ахмад хүнээ "Ta" гэж хүндэлнэ. Хүн бүр таньдаг таньдаггүй ахмад хүнийг "Ta" гэж хүндэтгээд, таньдаггүй үеийн хүнийг хэн ч байж болно, хэн нэгэн ухаантан авьяастан ч билүү хэмээн "Ta" гэнэ. Албан тушаал, зэрэг дэв, цол гуншин дээгүүр эрдэм номтой хүнийг дүү байсан ч ахмадууд "Ta" гэж хүндэтгэнэ. Ингээд эргэн тойрон гэр бүл, ойр орчин, олон даяараа бие биеийг "Ta" хэмээн хүндлэн "Ta"-ийн орчлонд амьдардаг ажээ. Тэгэхээр "Ta" хэмээн хүндлүүлсэн хэн бүхэн чухам тэр "Ta"-д тохирох хандагатай байх хэрэгтэй болно. Эдгээрийн дотроос гэр бүлийн доторх "Ta"-ийн хүндлэл нь хамгийн чухал бөгөөд та бидний хойч үе, үр хүүхэд чухам эндээс л "Ta"-г сурх бөгөөд нэг ангид тохой нийлэн сууж байсан нас чацуутныхаа эхнэр болж хэзээ хойно "Ta" хэмээн хүндлэн дуудахад амаргүй байгаа нь бас нэг юмыг хэлж байгаа хэрэг буй заа. Бүх хүн таны эргэн тойронд таныг, бас бие биесээ хүндлэн "Ta" гэж харилцаж байгаагаар та ч бас тесөөлөн бодоод үзээрэй.

Өнөөгийн монголчуудад дээрх уламжлалыг өөрчлөн "би" төвт үзлийг илүүчлэн өөрийн биеийг үнэлэн "би би би", "би өөрөө", "би бүтээсэн", "би хийсэн", "би л байна" гэсэн хандлага, түүнийг илэрхийлэх үг хэллэг элбэгших болов. Өөрийгөө танин мэдэхэд тохиолддог хамгийн том саад тогтор бол "би" гэдэг хүн бусдаас үл хамааран, бие даан оршиж байна гэх буруу бодол ухаан буюу "би"-гээ төвчлөн үзэх өрөөсгөл үзэлд оршино.

Чухам л "өөрийн толгой дээрх тэмээг үзэхгүй, хүний толгой дээрх өвсийг үзээд, өөрөө өмдгүй байж өвдөг цоорхойг шоолох" янзаар амьдарч, "өөрийн хүрзийг хайрлан хүний шанагаар хутгаж, өөрийн мууг хүнд тохож, өвлүйн мууг хаварт нялзаан", би л болж байвал бусад нь хамаагүй хэмээн бодож "би, чи, та"-аас "би" болоод "чи"-г илүү ашиглан ярилцаж байх шиг.

Монгол хэл, сэтгэхүй, соёл, хэрэглээний үүднээс "чи", "чи чи", "чи ганц" хэмээн хэлэлцэхийг төдийлөн дэмжихгүй, хүнийг хатгах мэт "чи чи" хэмээн хуруугаараа чичлэн ярихыг ихэд цээрлэн, хань ижлээ үхүүлж чухам л хүний тооноос хасагдсан гэмээр гон бие гозон толгой болсон хөгшин эмийг чи ганц (чавганц) гэдэг шигээр хэл ярианд "чи" гэсэн үг олон орох тусам үл хүндэтгэх утга нэмэгдэн хэрэлдэх, тэрсэлдэх санаа ургах мэт болно. "Чи" гэдэг үгийн өргөсөл нь чи муу, чи муухай, чи чадахгүй, чи мэдэхгүй, чи зайл, чи хэрэггүй гэх мэтээр дэлгэрэх нь илүүтэй.

Харамсалтай нь өнөө үед бид өөрийгөө "би би" хэмээн өргөмжилж, цээжээ дэлдэж, хэн ч байсан хүн бүхнийг "чи чи" хэмээн заан чичлэн дуудаж, миний хэрэг бүтэж байвал бусдын хэрэг падгүй гэж санан явах болсон шиг санагдана. Эртний сургаалд:

Та бээр бусад иргэн нөхдөө ч
 Таалж хүү шигээ тэгш асарваас
 Тэд цөм таныг эцэг шигээ бодож
 Тэргүүнээ дотночлон хүндлэх больюу.
 Албат иргэнээ “чи” гэж алагчлалгүй
 Адилхан тэгш, хүү шигээ тэтгэвэл
 Албат иргэн чинь чамайт эргээд
 Аав шигээ элбэрэн хүндлэх болно...

гэсэн байхад Буддын шашны сургаалд “би” буюу өөрийгөө төв болгосон сэтгэл батгуй, худал хоосон болохыг номлоод “би”-г бус бусдыг гэсэн сэтгэлийг өөртөө үүсгэвэл бодь мөрийн зэрэгт хүрч бурхан болж гэгээрнэ” гэж үздэг.

Монгол хэлний “өөрөө” гэдэг үг нь “би - өөрөө, чи / та - өөрөө “ гэх зэргээр аль ч биеийг төлөөлсөн үгтэй хамт хэрэглэгддэг онцлогтой (Баянсан, 2016:202).

Бүх мэдрэмжийн дотроос хүнд хамгийн ойрхон нь өөрийгөө хадгалах (хамгаалах), өөрийгөө авч үлдэх мэдрэмж юм. Тийм учраас түүний нь хөгжүүлэх гэж сурган хүмүүжүүлэгч дэмийн цаг үрэхийн ямарч хэрэгтгүйгээр хүнд угаасаа төрөлхийн шинж байдаг (Острогорский, 1985:61).

Монголын уламжлалт зан сэтгэлгээ, хэлэхүйд хүн өөрийгөө бусдаас дорд, молхи толхи, өчүүхэн мэтээр хэлж нэрлэн бусдыг эрхэм чухалд үзэж “Та” хэмээн хүндэтгэдэг билээ. Энэ нь “Би” гэж өөрийгөө дөвийлгөн цээжээ дэлдэхгүй, “Чи” гэж түмнийг чичлэхгүй, “Та” хэмээн хүндэтгэн харьцаас хүмүүсийн хайр хүндэтгэлийг хүлээсэн бусдаар өөрийгөө үнэлүүлдэг нандин заншилтай ард түмэн билээ. Энэ нь гэр бүлийн эрхэм хүндэтгэлт харилцаанд дэлгэрэнгүй байдаг. Жишээ нь: Гэр бүлийн эрхэм нандин харилцааны эхлэл болох нөхөр нь эхнэрээ “миний хань” хэмээн хайрлаж энхрийлнэ. Эхнэр нь нөхрөө бүхий л зүйлд “Та” хэмээн хүндэтгэн үзэх уламжлалт заншил сэтгэлгээ юм. Энэ уламжлал эдүгээ алдагдахад хүрч байгаа шалтгаан нь, гэр бүл болоход бие биеэ үзэх үзэлт, үнэлэмж, настын харьцаа (чацуу буюу эрдэм номын ширээнд тохой залган суусан үе тэнгийн) хоорондын харилцаа (нэг нэгнийгээ тэр үе шигээ “би, чи” гэх үл хүндэтгэн үздэг)-аас болж байна, Зүй нь харш биш ивээл болон сул жилтэнгүүд гэр бүл үүсгэвээс эхнэр нь “Та” гэх эрхэм нандин хүндэтгэлээр харилцан үүрдийн бат бэх амьдрал болох буйз за.

Одоох нийгэмд “би үхэхээр чи үх” гэсэн ёс суртахуун ноёлж байна. Хүн ямагт хүнийг хожих хонжихыг боддог, миний хэрэг л бүтэж байвал түүний хэрэг баларсан ч надад падгүй гэж аль муу сэтгэлийг үүсгэх болжээ.

Эр хүн бол айл гэрийн эзэн, нөхөр, ахмад нь эхнэр хүүхдээ хайрлаж халамжлагч нь байх, эм хүн буюу эхнэр нь дүүмэд, эр нөхрөө хүндлэн эв найр, бат бэхийг эрхэмлэгч байж үр хүүхдээ эрүүл саруул хүмүүжил боловсролтой болгох нь гол үүрэг ажээ.

Аялгуу сайхан монгол хэлний минь өчүүхэн эс хэсэг болох биеийг төлөөлөх цөөн үгсийг хэрхэн хэрэглэх нь үндэстний хэл, сэтгэхүй, соёлын хэмжээнд нөлөөлөх чухал хүчин зүйл, амь амьдрал, эрчим долгион, хэрэглээ буюу.

Резюме

Ключевые слова: происхождение личных местоимений, морфологическое значение, морфологическая функция, расширение значений.

В данной статье нами рассмотрена вопрос о личном местоимении монгольского языка “би, чи, та”, об их употреблении, о влиянии личных местоимений на общенациональную культуру и менталитет. Также мы постарались разъяснить молодому поколению о таких понятиях как “любить, уважать, выражать свои чувства” в традиционном понимании монголов.

Номзүй

Баянсан Ж. “Би”-ийн тухай монгол сэтгэлгээний онцлог. Ж.Баянсан. Хэл, соёл, үндэстний сэтгэлгээ. Уб., 2016, х.202-210.

Берис Б. Развитие Я - концепции и воспитание. Пер. с анг. М., Прогресс. 1986.

Острогорский А.Н. Избранные педагогические сочинения. М., Педагогика, 1985.

Ринчен Б. Монгол хэлний “на” гэдэг язгуур угийн учир. Studia Mongolica. T-IX, fasc. 4. Уб., 1973, х.37-39.

Төмөртогоо Д. Монгол хэлний түүхэн хэлзүйн үндэс-I. Монгол хэлний түүхэн авиа зүй. Уб., 1992.

Sečenčoγtu. Mongyul üges-ün ijayur-un toli. 1988.